



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 сарын 20 одор

Дугаар 02

Улаанбаатар

ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТ ЯВУУЛСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

Монгол улсын Засгийн газраас шинэ коронавирусүүн дэгдэлт тархалт, халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хорио цээрийн онцгой дэглэмийг тогтоож, өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан Компанийн тухай хууль, компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн Тахъко (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай асуудлаар эчнээ санал хураалтыг 2020 оны 03 дугаар сарын 16-19-ний өдрүүдэд явуулсан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд “Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурал хуралдуулах тухай” тогтоолын төсөл, холбогдох материалыг урьдчилан хүргүүлсэн бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт компанийн байр (МА-III барилга буюу Анкор төвийн хурлын заал)-нд хуралдуулахаар товлов. Хурлаар дор дурдсан асуудлыг авч хэлэлцэнэ. Үүнд:

- Компанийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- Компанийн 2019 оны жилийн тайлан тэнцэлд ээлжит аудит хийсэн компанийн аудиторын дүгнэлтийг танилцуулах;
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах зэрэг асуудлууд байна.

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, Тахъко (ХК) компанийн дүрмийн 7.1.3, 7.2.2 дугаар зүйлийн “б” хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу Тахъко (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурлыг хуралдуулах тухай тогтоолын төслийг батлах эсэх асуудлаар эчнээ санал хураалт явуулж, нийт 9 гишүүнээс 9 гишүүн саналаа ирүүлж, дээрх тогтоолын төслийг нийт гишүүдийн 100,0 хувийн саналаар дэмжиж батлав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТАНИЛЦСАН:
ТУЗ-ИЙН ДАРГА



Ш.МӨНХ-ОЧИР

Л.БУЯНБАТ